

**“МОНГОЛРОСЦВЕТМЕТ ТӨҮГ”-ИЙН ХЭНТИЙ АЙМГИЙН ДАРХАН СУМЫН
НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТЭЙ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫН 2023 ОНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-000173

РЕГИСТРИЙН ДУГААР: 2550466

2023 он

АГУУЛГА

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Төслийн нэр.....	2
1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл, төслийн хүчин чадал.....	2
1.3 Уурхайн дэд бүтэц	3
1.4 Уурхайн ажиллах горим	3
1.5 Усан хангамж	3
1.6 Цахилгаан хангамж.....	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ.....	4
ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	4
2.1 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч	5
2.2 Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг	5
2.3 Төсөл хэрэгжих талбайн гадаргын болон гүний ус.....	6
2.4 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал.....	6
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН.....	8
3.1 Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	8
3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл	8
3.3 Гадаргын болон гүний усан үзүүлэх сөрөг нөлөөлөл	9
3.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэжлэх хугацаа, эрчим	9
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	13
4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	15
4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	16
4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	16
4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	16
4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	18
4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	20
4.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ	21
5.1 ДҮГНЭЛТ	22

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1 Төслийн нэр

Хэнтий аймгийн Дархан сумын нутаг дэвсгэрт орших “АДАГ” хайлуур жоншны ордыг ашиглах төсөл.

1.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл, төслийн хүчин чадал

ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Үзүүлэлт	Х.нэгж	Дүн
Ерөнхий мэдээлэл			
1	Төсөл хэрэгжүүлэгч компани		“Монголросцветмет”ТӨҮГ
2	Компанийн улсын бүртгэлийн дугаар		9011027012
3	Тусгай зөвшөөрлийн дугаар		MV-000173
4	Ашигт малтмалын төрөл		Хайлуур жонш
Геологийн нөөц			
5	Бодитой (B) зэрэглэлийн нөөц	Хүдэр	мян.тн 667.2
		Эрдэс	мян.тн 247.97
6	Боломжтой (C) зэрэглэлийн нөөц	Хүдэр	мян.тн 215.8
		Эрдэс	мян.тн 75.78
7	Бодитой (B)+Боломжтой (C) зэрэглэлийн нөөц	Хүдэр	мян.тн 883.1
		Эрдэс	мян.тн 323.76
Үйлдвэрлэлийн нөөц			
8	Ил уурхайн хөрс хуулалт	мян.м ³	287.2
9	Ил уурхайн магадалсан (B) нөөцийн хэмжээ	Хүдэр	мян.тн 56.88
		Эрдэс	мян.тн 19.37
	Далд уурхайн магадалсан (B) нөөцийн хэмжээ	Хүдэр	мян.тн 665.87
		Эрдэс	мян.тн 208.13
10	Ил уурхайн хөрс хуулалтын дундаж итгэлцүүр	м ³ /т	5.05
Төслийн техник-технологийн шийдлүүд			
11	Жилийн хүчин чадал	мян.тн	150
12	Орд ашиглалтын хугацаа	Жил	5.4
12	Ашиглалтын технологи	Ил аргаар автотээвэртэй ашиглалтын	
		Далд аргаар дэд давхрын нураалт	
13	Баяжуулалтын технологи	Флотаци	
14	Цахилгааны эх үүсвэр	Өөрийн эх үүсвэр (дизель генератор)	
15	Усан хангамжийн эх үүсвэр	Гүний ус	
Эдийн засгийн хэсэг			
16	Борлуулалтын орлого	сая.төг	256,709
17	Нийт зардал	сая.төг	195,476
18	Татварын өмнөх ашиг	сая.төг	61,234
19	Татварын дараах цэвэр ашиг	сая.төг	48,293
20	1 тн хүдэр олборлох өртөг	Ил уурхай	төг/тн 78477.5
		Далд уурхай	төг/тн 68011.7
21	1 тн хүдэр баяжуулах өртөг	төг/тн	1028924.2
22	Нийт хөрөнгө оруулалт	сая.төг	10,380.7
23	Өнөөгийн үнэ, цэнэ NPV 10%	сая.төг	22,316
24	Өгөөжийн дотоод норм, IRR	%	54.8%
25	Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	жил	2.4
26	Улсын төсөвт оруулах татвар, төлбөр	сая.төг	44,359.1
27	Нэг ажилчны сарын дундаж цалин	сая.төг	1.83

1.3 Уурхайн дэд бүтэц

Уурхайн барилга байгууламж

Ажилчдын хотхон нэг дор 16 хүн байрлах ба нэг ээлжинд 8 хүн 12 цагийн 2 ээлжээр байрлана. Ажилчид таваараа амьдрах ажилчдын байр, конторын байр, хувцас угаалгын газар, бие засах болон ажилчдын халуун усны газар, дизелийн байр, агуулах, харуулын байр зэрэг барилга байгууламжууд байна. Агуулах, түлшний агуулах зэрэг байгууламжууд байна.

Хүснэгт 2 Байгууламжийн жагсаалт

№	Барилга байгууламж	Төрөл	Тоо
1	Дизелийн байр	сэндвич	1
2	Уурхайн хотхоны байр	контейнер	2
3	Цайны газар	контейнер	1
4	Халуун усны барилга	контейнер	1
5	Харуулын байр	сэндвич	1
6	Түлшний агуулах		1
Хэсгийн дүн			7

1.4 Уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горимыг уурхайн хүчин чадал, жилд гүйцэтгэх уулын ажлын хэмжээ, хэрэглэгчдийн хэрэглээний хугацаанаас хамааруулан жилд 10 дугаар сараас 12 дүгээр сарыг дуустал буюу 3 сарын хугацаанд ил уурхай долоо хоногт амралтгүй 16 цагийн 2 ээлжээр ажиллана. Уурхайн жилд ажиллах хоног 90 хоног.

1.5 Усан хангамж

Унд ахуйн хэрэгцээний усыг Бор-Өндөр УБУ-ын худгаас хангана. Уурхайн ногоон байгууламж болон замын усалгааны усыг шүүрлийн усыг хэрэглэнэ.

Талбайд хэрэглэгдэх усны хэрэгцээ нь:

- Унд, ахуйн хэрэгцээний ус
- Ногоон байгууламж усалгаа
- Замын усалгаа

1.6 Цахилгаан хангамж

Төслийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг DENYO маркийн дизель генераторуудаар шийдвэрлэнэ. Ордод ажиллах дизель генераторуудын техникийн үзүүлэлтийг дараах хүснэгтүүдэд үзүүллээ.


Хүснэгт 3 .Дизель генераторуудын үндсэн хэрэглэгчид

№	Үзүүлэлт	Дизель генераторын марк	Ажиллах тоо, ш
1	Ил уурхай угаан баяжуулах хэсэг	DENYO DCA 150USK	1
2	Ажилчдын хотхон, контор, засварын хэсэг	DENYO DCA 100ESI	1
3	Уурхайн гэрэлтүүлэг, Нөөцөд	DENYO DCA 150USK	1
Нийт			3

2.ТӨСЛИЙН ТАЛБАЙ ОРЧМЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

“Адаг”-ийн хайлуур жоншны орд нь засаг захиргааны хуваариар Хэнтий аймгийн Дархан сумын нутагт харьяалагдах бөгөөд Улаанбаатар хотоос зүүн урагш 305 км, Дархан сумаас баруун урагш 45 км, Хар Айрагийн төмөр замын өртөөнөөс зүүн хойд зүгт 47 км, Бор-Өндөрийн уурхайчдын хотхоноос зүүн хойш 18 км зайд оршдог.

- Трапецийн номенклатур: L-49-63
- Тусгай зөвшөөрлүүдийн нийлбэр талбайн хэмжээ: 69.35 га



Зураг № 1. Төслийн талбайн байрзүйн зураг

Төслийн талбайн Физик газарзүй:

Газар зүйн хувьд дунд зэргийн уулархаг бүсэд хамаарна.

Цаг уур : Энэ дүүрэгт өвөлдөө нилээд цас багавтар хүйтэн, зундаа бороо орох нь дунд зэрэг, халуувтар байх ба эх газрын эрс тэс уур амьсгалтай. 1-р сард хамгийн хүйтэн -30°C , 7-р сард хамгийн халуун 35°C хүрнэ. Жилдээ 130-411 мм тунадас унах бөгөөд дунджаар 244 мм орчим байна.

Ургамал, амьтан: Сумын нутаг дэвсгэрт тархсан хөрсийг шинж чанар газар зүйн байршил хөрс үүсгэгч нөхцөлөөр нь: 1.Долгиорхог тал, хээрийн ба өргөн хөндийн хөрс 2.Голын хөндийн, нугын хээршсэн хөрс 3.Уулархаг, уулын хөрс 4.Хээрийн элсэрхэг, хүрэн хөрс гэж хуваана. Долгиорхог хээр талын ба өргөн хөндийн хөрс зонхилох хувийг эзэлнэ. Дархан сум нь амьтны аймгийн төрлөөр баян нутаг билээ. Агнуурын ан амьтан. Чоно, үнэг, хярс, бор туулай, дорго, хүрнэ, мануул, цагаан зээр, тарвага зэрэг ан амьтан элбэг тааралдах ба сүүлийн жилүүдэд байгалийн хувьсан өөрчлөлт, хүний буруутай үйл ажиллагааны улмаас тарвага, цагаан зээр зэрэг агнуурын ан амьтад эрс ховордсон байна.

Хүн ам, дэд бүтэц: Ордын бүс нь үйлдвэр, уурхай, мал аж ахуй хөгжсөн Чойр Бор-Өндөрийн эдийн засгийн районд байрлаж байгаа бөгөөд хамгийн ойр орших суурин

газар нь Бор-Өндөр сум юм. Сумын төв нь Бор-Өндөрийн УБҮ уурхай, Баргилтын төмрийн ордууд болон бусад хувийн хэвшлийн ордуудыг түшиглэсэн арав гаруй уурхай, дэлгүүр, шатахуун түгээх станц, 10 орчим мянган хүн оршин суудаг томоохон суурингийн нэг бөгөөд Чингэс хотоос 80 км зайтай оршдог, төмөр зам, улсын эрчим хүчний нэгдсэн системд холбогдсон газар юм.

2.1 Төсөл хэрэгжих талбайн хөрсөн бүрхэвч


Хэнтий аймгийн Дархан сумын нутаг нь хөрс газарзүйн хувьд сав газрын хойт хэсэг нь Хэнтийн нурууны төгсгөл хэсгийн уулын тундрын болон уулын нугын хөрсний тойрогт, нутгийн дунд болон түүнээс хойш хэсэг нь Хэнтийн нурууны зүүн ба урд хэсгийн салбар уулсын уулын хар хүрэн ба хээрийн хар хүрэн хөрсний тойрогт, хэсэг нь хуурай хээрийн бүсийн ухаа гүвээт, удам хөндийн хүрэн хөрсний тойрогт ордог.



2.2 Төсөл хэрэгжих талбайн ургамлан нөмрөг

Хэнтий аймгийн Дархан сумын нутаг нь ой модгүй, зарим хэсэгтээ бутлаг болон уулы ар билээр бургас, харгана, ховроор бургасан төгөлтэй. Хотгор хонхор, нам дор газруудаар нь олон төрөл өвслөг ургамал ургана. Бүс нутгийн хойд, зүүн хойд хэсгээр Аллювийн нугын төрлийн ургамал зонхилох бөгөөд уулсын эгц налуу, хадархаг, өндөрлөг газруудаар нь ургамлын бүрхэвч тачир байна. Түр зуурын голын татам, голын тохой буланд хайлаас, бэсрэг хус, улаан бургас зэрэг модлог ургамлын цөөн төрлүүд ургана.

ХЭНТИЙ АЙМГИЙ ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг № 4. Төслийн талбайн ургамалжилтийн зураг

Зургаас үзэхэд ургамлын массын болон ургамлын төрөл зүйлийн хувьд өмнөх жилүүдтэй харьцуулбал энэхүү хэсэгт харьцангуй баян байгаа нь тухайн жилийн уур амьсгалын нөхцөл байдалтай холбогдож байна. Төслийн талбай нь газар ашиглалтын ангиллаар ХАА-н газар, бусад газар гэсэн ангилалд хамаарагддаг байна.

2.3 Төсөл хэрэгжих талбайн гадаргын болон гүний ус

Хэнтий аймгийн усны нөөц нь газрын доорх ус, гол горхи, нуур, усан сангаас бүрддэг бөгөөд гадаргын болон гүний ус нь усны нөөцийн ихэнх хувийг бүрдүүлдэг. Төслийн талбайн орчим гүний ус байхгүй ба Бор-Өндөр сумын гар худгаас дээж авч шинжлүүлэхэд үндсэн үзүүлэлтүүдээс ерөнхий хатуулаг болон магнийн ионы агууламж нь “Ундны усны чанарын стандарт MNS900:2018”- д заасан хэмжээнд байгаа тул хүний унданд тохиромжтой.

2.4 Төсөл хэрэгжих орон нутгийн нийгэм эдийн засгийн байдал

Бор-Өндөр сумын газар нутаг: Сумын нутаг дэвсгэрийн ихэнх нь далайн түвшнээс дээш 1200-1500м өргөгдсөн Хэнтийн нурууны салбар уулсын урд, уудам тал хээр, уулархаг аараг, толгод хосолсон нутагтай, мал аж ахуй, уул уурхай эрхлэхэд тохиромжтой. Газар хөдлөлийн 5-6 баллын идэвхтэй бүсэд байршдаг. Ил задгай ус багатай, 50 энгийн болон инженерийн хийцтэй худагтай.

Хэнтий аймгийн засаг, захиргаа: Хэнтий аймаг нь Монгол улсын нутаг дэвсгэрийн зүүг хойд хэсэгт, нийслэл Улаанбаатар хотоос 300 км зайтай оршдог. Дорнод, Сүхбаатар, зэрэг 6 аймагтай нутаг залгаж орших ба 80,3 мянган хавтгай км² нутагтай. Хэнтий аймаг нь засаг, захиргааны 18 сумтай. 2017 оны байдлаар 73,6 мян хүн амтай.

Эрүүл мэнд: Суманд 15 ортой 1 эмнэлэг, 5 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 2 их эмч, 13 эмнэлгийн тусгай мэргэжилтэн ажиллаж байна. Сумын ард иргэдэд нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх өрөө тасалгаа хүрэлцээгүйгээс сургалт сурталчилгаа явуулах сургалтын өрөө байхгүй.

Боловсрол, соёл шинжлэх ухаан: Сумын ерөнхий боловсролын 12 жилийн сургуульд 3000 хүүхэд өдрөөр суралцаж, албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр бага, суурь, бүрэн дунд боловсрол нөхөн олгох сургалтанд 35 иргэн суралцаж байна. Бага ангийн хамран сургалт 99,1 хувь, суурь боловсролын хамран сургалт 98,3 хувьд хүрсэн. Ерөнхий боловсролын сургуульд мэргэжилтэй багшийн хангалт 100 хувь байна. Нийт 100 гаруй багш, ажилчидтай үйл ажиллагааг явуулж байна. Мөн хувийн сургууль үйл ажиллжгжж явуулдаг.

Аж үйлдвэр: Жонш, төмөр олборлолт, боловсруулах үйлдвэр нь тус хотын эдийн засгийг тэтгэдэг бөгөөд анх Бор-Өндөр нь жоншны үйлдвэрийг түшиглэн байгуулагдсан юм. Монгол-Оросын хамтарсан Монголросцветмет ТӨҮГ тус жоншны уурхай, үйлдвэрийг голлон эзэмшдэг. Үйлдвэрийн бүх бүтээгдэхүүн ОХУ, Украин, Хятад зэрэг орнууд руу төмөр замаар дамжин экспортлогддог[2]. Уулын баяжуулах үйлдвэр нь 1981 онд ашиглалтанд орсон одоогийн байдлаар нийт 1135 ажилтан ажиллаж байна. Хүчин чадал: Жоншны хүдэр олборлолт 300,000-360,000 тн 95%-н агуулгатай хайлуур жонш/caf2/ 140,000-160,000 тн 75%-н агуулгатай бүхэллэг жонш 15,000-20,000 тн 65%-н фторын агуулгатай төмрийн баяжмал 500,000 тн Хуурай төмрийн баяжмал 205,000 тн Нойтон төмрийн баяжмал 250,000 тн тус тус олборлож байна

Мөн Герман улсын “Констант” пүүсийн тусламжтайгаар баригдсан мах боловсруулах үйлдвэр ажилладагийн зэрэгцээ гахай үржүүлэх цогцолбор, Хэнтий аймгийн МХГ-ын хяналтын алба, Татвар, Нийгмийн даатгалын тасаг, УБТЗ-ын Бор-Өндөр өртөө, Гүний гаалийн салбар, Бор-Өндөр цогцолбор сургууль, хувийн Их-Ирээдүй дунд сургууль, “Энхжин”, “Бүжинхэн” болон “Нархан” цэцэрлэг, Сум дундын шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Цагдаагийн хэлтэс, Хас банк, ХААН банк, Төрийн банкны салбарууд, Эргэлтийн эмийн сан, Холбооны салбар, Монгол шуудан, Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эмнэлэг, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв зэрэг төрийн болон түшиглэсэн байгууллагууд үйл ажиллагаа явуулж байна.

Тус хотын нутаг дэвсгэрт тохижилт үйлчилгээний “Бор-Өндөр хот тохижилт” ОНТҮГ, худалдааны “Пүрдэм” ХХК, “Дэлгэрнуур” ХХК, “Морьтын даваа” ЗБН зэрэг томоохон ААН, 100 гаруй жижиг дунд худалдаа үйлчилгээний цэг салбарууд хотын иргэдэд үйлчилж байна.

Сумын хэмжээнд 2017 оны байдлаар нийт 77,014 мянган мал тоологдсон.бэлчээрийн хомсдол ажиглагдаж буй.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛИЙН

3.1 Агаарын орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

Агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд

“АДАГ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ордыг ашиглах явцад агаарын чанарт нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд нь:

- Хөрс хуулах, хүдэр олборлох үед тоос, шороо ихээр үүсгэнэ.
- Уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос, шороо
- Уурхайн машин техникүүдийн түлшний шаталтаас ялгарах утаа, тортог, хорт хийнүүд
- Ажилчдын суурингаас гарах хатуу шингэн хог хаягдлын бохирдол
- Өрөмдлөг, тэсэлгээний ажил хийх үед гарах тоос, шороо

Хөрс хуулах, түрэх, тээвэрлэх, элс угаах зэрэг бүхий л ажиллагаа тасралтгүй явагдах тул бульдозер, экскаватор, автомашин, бусад төхөөрөмжийн дуу чимээ болон хорт хий утаа гарах, тоос шороо дэгдэх зэргээр агаар орчныг бохирдуулж, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлнө. Үүнээс гадна барилга угсралтын үйл ажиллагаа болон тээврийн хөдөлгөөнтэй холбоотойгоор агаарын бохирдол үүсч болзошгүй.

3.2 Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл

“АДАГ” ХАЙЛУУР ЖОНШНЫ ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн 2 сарын хугацаанд нийт 1,26 га талбай өөрчлөлтөнд орж хөрсөн бүрхэвч нөлөөлөлд өртөхөөр байна. Төслийн хүрээнд төлөвлөж буй уурхайн барилга байгууламжид хөрс удаан хугацаанд дарагдана. Түүнчлэн дэд бүтцийн барилга, байгууламжийн ойр орчимд машин техник, хүний үйл ажиллагаагаар элэгдэл, эвдрэл, бохирдол их үүснэ. Уурхайн үйл ажиллагааны явцад нүүрс-ус буюу шатахуун, түүнтэй төстэй бүтээгдэхүүн, мөн химийн бодисын асгаралт, шүүрэлтээс хөрс бохирдох боломжтой. Шатахуун болон химийн бодисын агуулах, сав, машин техникийн тээвэрлэлт ачаалалтын үед асгаралт үүсэж хөрсний боломжит бохирдол ихэнхдээ үүсдэг. Асгаралтын хэмжээ, түүний нөхцөл байдлыг зөв үнэлсэн тохиолдолд түүнийн нөлөө бага байдаг, ялангуяа, шаардлага хангасан шатахууны агуулах, асгаралтын хариу арга хэмжээ сайн байхаас хамаарна. Эдгээр арга хэмжээг Аюултай, хортой материалын менежментийн төлөвлөгөөнд тодорхой тусгасан байх ёстой.



*Зураг № 7.
Төсөл
хэрэгжих
талбай
орчмын
хөрсөн
бүрхэвч*

3.3 Гадаргын болон гүний усан үзүүлэх сөрөг нөлөөлөл

Гадаргын болон газрын доорх усанд нөлөөлөл үүсгэх эх үүсвэрүүд

Төслийн үйл ажиллагааны явцад дараах эх үүсвэрүүдээс гадаргын болон газар доорх усны нөөц, чанарт нөлөөлөл бий болж болзошгүй. Үүнд:

- Хөрс хуулалт болон барилга угсралтын явцад тоосжилт дарахад цэвэр усны нөөц хомсдох
- Уулын малталтын үед хөрсний болон гүний усыг зайлуулж усны нөөц хомсдох
- Барилга угсралтын ажлын явцад барилгын материал хур тунадас болон үерийн усаар угаагдан барилгын материалд агуулагдах бодисууд хөрсөнд нэвчих, улмаар хөрсний бага гүний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах савыг соруулах үед асгарч газрын хэвлий болон хөрсийг бохирдуулахаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- Уулын ажлын болон ахуйн бохир ус хадгалах сав хүчтэй аадар бороо болон үерийн усаар дүүрч хальхаас үүдэн хөрсөнд нэвчиж хөрсний ус болон бага гүний усыг бохирдуулах
- Техник, тоног төхөөрөмжийн шатах тослох материал алдагдаж хөрсийг бохирдуулхаас үүдэн хөрсний усыг бохирдуулах
- Уурхайн байгууламж, хоосон овоолго, хаягдлын сан, техник хэрэгслийн байршуулалт зэргээр газрын гадаргыг өөрчилж улмаар байгалийн хур тунадас унаж урсац бүрдэх, хөрсний чийг, газрын доорх усыг сэлбэх нөхцөлийг доройтуулах магадлалтай.

3.4 Төслийн болзошгүй сөрөг нөлөөлөл үргэлжлэх хугацаа, эрчим

Байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл, үргэлжлэх хугацаа, эрчим: Уг төслийг хэрэгжүүлснээр байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг тогтоохдоо байгаль орчны суурь нөхцөл, судалгаа хийсэн мэргэжлийн судлаачдын дүгнэлтүүдийг үндэслэн тогтоов. Байгаль орчны төлөв байдалд гарч болзошгүй нөлөөлөл, болзошгүй ослын үнэлгээг магадлан жагсаах аргаар тодорхойлов.

Магадлан жагсаах /checklist/ аргаар тооцсон нөлөөллийн үнэлгээ: Үнэлгээ хийгдэж буй төслийн үйл ажиллагаа байгаль орчны төлөв байдал, нийгэм эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчмийг тодруулахын тулд магадлан жагсаах (checklist) аргыг ашиглав. Энэ арга нь нөлөөллийг байна (х), байхгүй (хоосон) гэсэн хэлбэрээр тодорхойлж шууд, шууд бус шинжтэй, удаан, богино хугацаагаар буцалтгүй болон буцаж нөлөөлөх, хүчтэй, дунд болон бага зэрэг эрчимтэй байх зэрэг үзүүлэлтүүдээр авч үзсэн болно.

Төслийн байгаль орчинд сөргөөр нөлөөлөх эх үүсвэрүүдэд дараах хүчин зүйлс орж байна. Үүнд:

- ✚ Хөрс хуулалт
- ✚ Уурхайн олборлох, ачих, буулгах, тээвэрлэх үйл явц.


Төсөл хэрэгжсэнээр тухайн нутгийн байгаль орчны төлөв байдалд үзүүлж болзошгүй нөлөөллийг хүснэгт 4-д харуулав.

ХЭНТИЙ АЙМГИЙ ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 4. Магадлан жагсаах арга

№	Байгаль орчны үзүүлэлт	Нөлөөлөл			Хугацаа		Давтамж		Эрчим		
		Шууд	Шуудбус	Өөрөө зохицуул	Богино хугацаа	Удаан хугацаан	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Багазэрэг	Дундээрэг	Хүчтэй
Байгалийн экосистемийн өөрчлөлт											
1	Газрын доорх урсацын өөрчлөлт										
2	Гадаргын усны чанарын өөрчлөлт		x			x	x			x	
3	Ургамлан бүлгэмдлийн бүтцийн өөрчлөлт	x				x		x			x
4	Хөрсний элэгдэл, эвдрэл	x				x		x			x
5	Геологийн тогтоцын өөрчлөлт	x				x		x		x	
6	Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	x				x		x		x	
7	Уур амьсгалын өөрчлөлт					x		x	x		
Байгалийн нөөцийн ашиглалт											
8	Газрын доорх нөөц баялаг	x				x		x		x	
9	Бэлчээрийн байдал	x				x		x		x	
10	Эрдэс түүхий эдийн нөөц	x				x		x		x	
Байгаль орчны чанарын өөрчлөлт											
11	Агаарын бохирдол	x			x		x				
12	Ундны усны нөөц хомсдох		x			x		x	x		
13	Хөрсний бохирдол		x				x				
14	Дуу чимээ, шуугианы нөлөөлөл	x			x	x		x			
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл											
15	Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөл	x				x		x	x		
16	Хүн амын орлого өөрчлөгдөн нэмэгдэх		x			x		x	x		
17	Хүн амын тоо өөрчлөгдөх		x			x		x	x		
Байгалийн цогцолборт газар, түүх соёлын дурсгалт зүйл, археологи, палентлогийн олдвор											
18	Байгалийн өнгө төрх өөрчлөгдөх	x				x		x		x	
19	Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	x				x		x	x		
20	Тусгай хамгаалалттай ба цогцолборт газарт нөлөөлөх										
21	Түүхсоёлын дурсгалт Зүйлд нөлөөлөх										
22	Археологи, палентлогийн олдворт нөлөөлөх										
Эдийн засаг, байгаль орчин											
23	Орон нутгийн орлого нэмэгдэх		x			x		x		x	
24	Ажлын байр нэмэгдэх										
25	Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох										
Бусад нөлөөлөл											
26	Шороон зам, уурхайн машин механизмын хөдөлгөөн, тээвэрлэлтээс хөрс эвдрэх	x				x	x			x	x
27	Ахуйн бохир ус, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж, хөрс ба усыг бохирдуулах	x				x	x			x	
28	Ахуйн хаягдал, хогийн цэгийн ариутгал муугаас эвгүй үнэр гарах, шавьж үржих	x			x		x			x	
29	Хүчтэй салхи, уруйн үер	x			x		x			x	
30	Дүн	18	8		5	20	7	18	5	15	6

Дээрх хүснэгтээс харахад тус төслийн үйл ажиллагааны явцаас байгаль орчинд нөлөөлөх нөлөөлөл өөр хоорондоо харилцан уялдаа холбоотой нэг нь нөгөөдөө шууд буюу дам байдлаар нөлөөлөх нь харагдаж байна.



Тус ордыг ашиглах төслийн үйл ажиллагаанаас сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрэлдэхүүн хэсэг тус бүрд үзүүлэх ба 7.1% нь “бага”, 45.2% нь “дунд”, 42.8% нь “их”, 4.8% нь “маш их” гэсэн нөлөөллийн үнэлгээний зэрэгт хамаарагдаж байна. Нөлөөлөлд өртөж буй байгалийн бүрэлдэхүүн хэсгүүдээс газрын гадарга, хэвлий нь нөлөөлөлд илүүтэйгээр өртөхөөр байна.

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хэнтий аймгийн Бор-Өндөр сумын нутаг дэвсгэрт “Монголросцветмет ТӨҮГ” хэрэгжүүлж буй “АДАГ” хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн үнэлгээний ажлын явцад үйл ажиллагааны товч танилцуулга, эрхлэхээр төлөвлөж буй үйл ажиллагааны тодорхойлолт болон төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн суурь төлөв байдлыг тодруулж үйл ажиллагааны явцад байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлэх гол сөрөг нөлөөллүүд тэдгээрийн цар хүрээг тооцон сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, багасгах арга хэмжээний зөвлөмжийн хүрээнд энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) боловсрууллаа.

Төслийн хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн бүтээн байгуулалт, уурхайн олборлолтын үйл ажиллагааны улмаас хамгийн ихээр эвдрэлд орж сөрөг нөлөөлөлд өртөх бүрэлдэхүүн нь хөрсөн бүрхэвч юм. Сөрөг нөлөөллийн цар хүрээ багаас дунд зэрэг ба урьдчилан сэргийлэх болон бүтээн байгуулалтын дараа болон олборлолт дууссан хэсэгт нөхөн сэргээх талаар төлөвлөсөн арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэх тохиолдолд нөлөөллийн эрчим эрс буурах боломжтой.

Төслийн ерөнхий үнэлгээний нөхцөлд заагдсаны дагуу байгаль орчныг хамгаалах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар жил бүрийн төлөвлөгөөг БОАЖЯ-ны Сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн А/618 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу тухайн жилийн Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг энэхүү тайлангийн 2 жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг (БОМТ) үндэслэн боловсруулж БОАЖЯ-д ирүүлэн батлуулах ба батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэсэн ажлын тайланг холбогдох газруудад хүргүүлж байх шаардлагатай. Үүнээс гадна тус Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ), түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь”-ийн дагуу оролцогч сонирхогч талуудыг холбогдох мэдээллээр ханган ажиллах үүргийг төсөл хэрэгжүүлэгч хүлээнэ.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 10,0 сая.төг зарцуулахаар төсөвлөв.

ХЭНТИЙ АЙМГИЙ ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
Агаар орчин					
Уурхайн олборлолт болон тээврийн хэрэгслүүдийн үйл ажиллагааны улмаас гарч болох тоосжилтыг бууруулах	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Үйл ажиллагааны турш	Хуурайшилт ихтэй үед 7 хоногт 3 удаа	0,3	БОС-ын 1995 оны 153 тоот тушаал
	Уурхайн карьерт орж гарах машин, ачилт буулгалтын цаг хугацаа, хоорондын зайг тоосны сарнилтай уялдуулан оновчтой байлгах тооцоог хийж мөрдөж ажиллах	Үйл ажиллагааны турш	Ашиглалтын хугацаанд	-	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885;2008
	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны турш	Ашиглалтын хугацаанд	0,3	
	Хүнд машин механизмын утааны хэмжээг стандартын шаардлага хангах хэмжээнд байлгах, үзлэг шалгалтыг хийх, засвар үйлчилгээг тогтмол хийх	Үйл ажиллагааны турш	Жил бүр	ҮА-ны зардал	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885;2008
Төслийн үйл ажиллагаанаас үүсэх тоосжилт Тэсэлгээний ажлын үед үүсэх тоосжилт	Уурхайн ажиллагсад тоосноос хамгаалах хошуувч, амны хаалт, хүнсний нэмэлт бүтээгдэхүүнээр ажилчдыг ханагах, сургалт явуулах.	Үйл ажиллагааны турш	Жил бүр	ХХАА-ны зардал	MNS13688;2000 MNS3306;1991 MNS5620;2006 MNS5623;2006 MNS5388;2004 MNS5389;2004
Хөрсөн бүрхэвч					
Ордын ашиглалтын явцад хөрсний бүтэц найрлагад өөрчлөлт орох, хогхаягдал, тоосжилтоос бохирдол үүсгэх, хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж	Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх ажил хийх, олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	Жил бүр	0.3	
	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтанд хяналт тавих	Үйл ажиллагааны турш	Жил бүр	-	
	Машин механизмын засвар үйлчилгээ хийх талбайд бетон хучилт хийх	Үйл ажиллагааны турш	Жил бүр	Барилгын ажлын зардал	

ХЭНТИЙ АЙМГИЙ ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

хөрс болон ургамлыг гэмтээх. Шатах тослох материал, барилгын материалын хог хаягдал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	Жил бүр	ҮА-ны зардалд	
	Автомашин хурдыг боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	Жил бүр		
Ус					
Гүний усыг ашигласнаар усны нөөц хомсдох, усны бохирдол, шатах тослох материалыг алдсанаар газрын доорх ус бохирдох, газар доорх устай холбогдон ургадаг ургамалжилтанд сөргөөр нөлөөлж болзошгүй.	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах,	Жил бүр	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах	Жил бүр	Ахуйн бохир усыг цэвэршүүлэн ногоон байгууламжийн усалгаанд ашиглах,
	Үйл ажиллагааны турш	Жил бүр	Үйл ажиллагааны турш	Жил бүр	Үйл ажиллагааны турш
	Ус ашиглалтын дүгнэлт гаргуулж, гэрээ байгуулах	Жил бүр	Үйл ажиллагааны турш	Жил бүр	Үйл ажиллагааны турш
Дуу чимээ					
Нутгийн иргэдийн амгалан тайван байдлыг алдагдуулах	Олборлолтын ажлыг өдрийн цагаар гүйцэтгэх	Үйл ажиллагааны турш	Жил бүр		MNS ISO 226:2003 дуу чимээ хэвийн норм түвшний хэмжээ
	Дуу шуугианы хэмжилт (2 цэгт дууны түвшин хэмжигч NL-04 багажаар) хийж, дуу, шуугиан бүхий машин механизмийн ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах	Үйл ажиллагааны турш	Улиралд нэг удаа дууны түвшин хэмжигч NL-04 багажаар хэмжилт хийнэ.	0,1	

ХЭНТИЙ АЙМГИЙ ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг 2023	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
Техникийн нөхөн сэргээлт						
Техникийн нөхөн сэргээлтийн ажил дууссаны дараагаар талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил эхлүүлэх	Өмнө жилүүдэд эвдэгдсэн дахин ашиглалт явуулахгүй газрын техникийн нөхөн сэргээлийн ажлыг гүйцэтгэнэ	Уурхайн үйл ажиллагааны явцад	2023 11 сар	0,5	Нөхөн сэргээлтийн зардалд	“Байгаль орчныг хамгаалах тухай”
						“Ашигт малтмалын тухай”,
						“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” MNS5915:2008, MNS5916:2008, MNS5917:2008
Нийт дүн сая.төг					0,5	

4.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
Дүйцүүлэн хамгаалах менежментийн төлөвлөгөө					
Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарих	1000 ширхэг хайлаас, шар хуайс тарих	Ашиглалтын талбайн хөндөгдөхгүй хэсэгт	11 дугаар сарын 01-ны өдрийн дотор	3,5	MNS 5914:2015, MNS 4597:2013
Нийт дүн сая,төг				3,5	

4.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул 2023 оны БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

4.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

4.6. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Хэрэгжүүлэх хугацаа (он), сая.төг 2023	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ					
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Нийт төсөл хэрэгжих талбай барилга байгууламжинд	Жил бүр	0.5	Гамшгаас хамгаалах тухай хууль
	Галын болон байгалийн аюул гамшигаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Уурхайн бүх ажилчдад	Уурхайн БО-ны мэргэжилтэн хариуцна, Жилд 1 удаа	0,5	
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш			
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах,	Үйл ажиллагааны турш	Жил бүр	0.5	
Нийт дүн сая.төг				1,5	

ХЭНТИЙ АЙМГИЙ ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийг хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал мян. төг	Төсөл хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт, стандарт
Олборлолтын явцад гарсан хог хаягдлыг ил задгай хаях, ил задгай хог хаях талбайг цэвэрлээгүйгээс хог хаягдал үүсч байгальд сөрөг нөлөө үзүүлэх. - Шингэн хог хаягдлыг шууд ил задгай хаяснаар хөрсөнд сөрөг нөлөө үзүүлэх	Хатуу хог хаягдлын түр цэгийн хөрсийг бетондож, битүүмжлэл сайтай 3 тасалгаатай хатуу хаягдлын цэгийн стандартын шаардлагад нийцүүлэн хөрснөөс тусгаарласан битүүмжлэл сайтай галд тэсвэртэй материалаар доторлох	Төслийн талбай	Ширхэг	0,75	1	0,75	Төсөл хэрэгжиж эхлэхийн өмнө	Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011 -Хог хаягдлын тухай хууль
	Уурхайн кемпээс үүссэн хатуу хог хаягдалыг сумын засаг даргын тамгын газартай гэрээ байгуулан тээвэрлүүлэх гэрээ байгуулах.	Төслийн талбай	-	-	Сард 1 удаа	0,75	Сар бүр	
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний нийт: мян/төг							1,5	

ХЭНТИЙ АЙМГИЙ ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

4.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян/төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Агаарын чанар					
24 цагийн хэмжилтийг хийж (O3, SO2, NO2, CO нийт тоосонцор, PM 10, PM 2.5, Pb, бензапирен, температур, агаарын урсгалын хурд, харьцангуй чийглэг, гэрэлтүүлэг	Төслийн талбай	Төсөл хэрэгжих талбайд хяналтын 2 цэг сонгож, зонхилох салхины доод ба дээд талд сар болгон хийнэ	0,2	Цаг уур орчны шинжилгээний газрын байгаль орчны хэмжил зүйн төв лаборатори	MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, MNS 3384:1982 Сорьц авахад тавих ерөнхий шаардлага, MNS 4048:1988 Тоосны хэмжээг тодорхойлох жингийн арга MNS 0017-2-5-11:1988 Агаар дахь азотын давхар ислийн хэмжээг тодорхойлох фотоколориметрийн арга, MNS 5013:2009 Бензин хөдөлгүүртэй автомашин. Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга, MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин. Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшиний хэмжээ
Дуу шуугиан чичиргээний шинжилгээ	Төслийн талбай	Жилд 1 удаа	0,2	ЦУОШГ Байгаль орчны хэмжилзүйн төв лаборатори	
Хөрсний шинжилгээ					
Хөрсний химийн үзүүлэлт (рН, Давс, ЦДЧ, CO ₂ , Ялзмаг, Ca+Mg, Ca, Mg P ₂ O ₅ , K ₂ O)	Төслийн талбай	Жилд 1 удаа	0,3	Ландовнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад
Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Cu, Zn)	Төслийн талбай	Жилд 1 удаа	0,3	Ланд овнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	

ХЭНТИЙ АЙМГИЙ ДАРХАН СУМЫН НУТАГТ ОРШИХ “АДАГ” НЭРТ ХАЙЛУУР ЖОНШНЫ ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хөрсний эрүүл ахуй (нянгийн тоо, гэдэсний савханцарын титр, анаэробын)	Төслийн талбай	Жилд 1 удаа	0,3	Ланд овнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	тавигдах ерөнхий шаардлага MNS ISO 11047:2001 Хөрсний чанар. Хөрсний усан орчны хандмалд кадми, хром, кобальт, зэс, хар тугалга, мангани, никель, цайрыг тодорхойлох. Дөлний болон цахилгаан дулааны атомын шингээлтийн спектрометрийн арга MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга MNS 5850:2008 Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
Усны чанар					
Усны химийн ерөнхий шинжилгээ (Cl, SO ₄ , NO ₂ , SO ₃ , CO ₃ , NO ₃ , HCO ₃) ерөнхий хатуулгын хэмжээ, исэлдэх чанар, физик шинж чанар	Баригдсан барилгын усных үүсвэрээс	Жилд 1 удаа	0,2	ШУА, Газарзүй- Геоэкологийн хүрээлэн, усны шинжилгээний лаборатори	MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх- дээж авах, хадгалах, зөөвөрлөх
Орчны хяналт шинжилгээний нийт зардал мян/төг		1,5			

4.9. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Хариуцсан албан тушаалтан	Хэрэгжүүлэх хуваарь	Хэрэгжүүлэх хугацаа он /сая төг/	Тайлбар
УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАХ				
Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам боловсруулж мөрдөх	ХАБ-ын мэргэжилтэн	Жил бүр	Уурхайн дотоод төлөвлөлтөөр	
Байгаль орчныг хамгаалах, үйлдвэрлэлийн осол, гал түймэр, усны аюул мэтийн гэнэтийн ослоос урьдчилан сэргийлэх, осол гарсан тохиолдолд шуурхай хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах талаарх сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран жилд 1 удаа зохион байгуулах	ХАБ-ын мэргэжилтэн		-	
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	ХАБ-ын мэргэжилтэн	-		
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт жил бүр тогтмол хамруулах. Ажлын онцлогоос хамааруулан хувь хүний хамгаалалтын хэрэгслээр тогтмол хангах, хордлого тайлах хүнс, бэлдмэлээр хангаж байх	Уурхайн эмч,	Жил бүр	Осол эрсдэлийн МТ-нд тусгагдсан	
Галын аюулаас хамгаалах хэрэгсэл, эрүүл ахуйн хэрэгслээр хангах	ХАБ-ын мэргэжилтэн		1,0	
Нийт дүн сая.төг		1.0		

4.10. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗАРДАЛ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө /2023 он/	сая/төг
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	1,0
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	0,5
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	3,5
Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	1,5
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	1,5
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,0
Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.	1,0
Нийт	10,0

5.1 ДҮГНЭЛТ

Хэнтий аймгийн Дархан сумын нутагт орших “Адаг” нэрт хайлуур жоншны орд нь 69,35 га талбайг хамаардаг. “Адаг”-ын хайлуур жоншны ордын хэмжээнд нийт (B) зэрэглэлээр 660.28 мян.тн, боломжит (C) зэрэглэлээр 228.43 мян.тн, нийт “B+C” зэрэглэлээр 883.72 мян.тн хайлуур жоншны хүдрийн нөөцийг 2021 оны 12-р сарын 25-ны өдөр Монгол улсын Эрдэс Баялгийн Мэргэжлийн Зөвлөл (ЭБМЗ)-өөр хэлэлцүүлэн батлуулсан. Ил уурхайн оновчтой хүрээ хязгаарыг тогтоосны үндсэн дээр ордыг ил уурхайн болон далд уурхайн аргаар хослуулан ашиглахаар төслийн ТЭЗҮ-д тусгасан байдаг.

Төсөлд ил уурхайн жилийн хүчин чадал 60.0 мян.тн хүдэр буюу ил уурхайн ашиглалтын хугацаа 0.6 жил, далд уурхайн жилийн хүчин чадал 150.0 мян.тн хүдэр буюу далд уурхайн ашиглалтын хугацаа 4 жил байхаар тооцож төслийг боловсруулсан.

Төслийг ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх хамгийн гол сөрөг нөлөөлөл нь ил болон далд уурхайн олборлолтоор газрын хэвлийд хоосон орон зай үүсэх, газрын гадарга эвдрэлд өртөх, олборлолт тээвэрлэлтийн явцад үүсэх тоосжилт, тээврийн хэрэгслээс үүсэх утаа агаар орчныг бохирдуулах, дуу чимээний нөлөөлөл үүсэх, тээврийн хэрэгслээс үүсэх олон салаа зам гарах, хог хаягдлаас орчны бохирдол үүсгэх зэрэг болно.

Иймд тус БОМТ-гөөр 2023 оны 10 дугаар сараас 12 дугаар сарыг хүртэлх хугацаанд уурхайн ашиглалт олборлолтын явцад үүсгэх дээр дурдсан гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийг хамгийн бага түвшинд байлгах чиглэлээр арга хэмжээнүүдийг төлөвлөн боловсруулав.

БОМТ-нд 10,0 сая төгрөг зарцуулахаар төсөвлөж, тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, холбогдох стандарт, дүрэм журам, хууль тогтоомжийг тусган, зардлын задаргааг байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардлын хэсэгт оруулав.